



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/97

Хэрлэн сум

Төсөл арга хэмжээний гэрээ байгуулах
болон худалдан авах ажиллагаа зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.21, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.6, 8.7 дахь хэсэг, Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 18 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Барилга, хот байгуулалтын сайдын 2023 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 32 дугаар тушаалын дагуу Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад заасан IX.1.131 дугаартай “Сумдын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээ (Хэнтий, Баян-Адарга, Баян-Овоо, Баянхутаг, Дадал, Дэлгэрхаан, Мөрөн, Норовлин, Цэнхэрмандал сум, Батноров сум, Бэрх тосгон)”, IX.1.47 дугаартай “Сумын төвийн гадна цэвэр усны шугам сүлжээ (Хэнтий, Жаргалтхаан сум)”, IX.1.70 дугаартай “Цэвэр усны гадна шугам сүлжээ (Хэнтий, Өмнөдэлгэр сум)”, IX.1.77 дугаартай “Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ (Хэнтий, Хэрлэн сум)” төсөл арга хэмжээний гэрээ байгуулах болон худалдан авах ажиллагааг зохион байгуулсугай.

2. Төсөл арга хэмжээнүүдийн гэрээ байгуулах болон худалдан авах ажиллагааны дүн, санхүүжих дүнг хавсралтаар баталсугай.


3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Аймгийн засаг даргын 2023 оны 2 дугаар сарын 02-ны А/61, 2023 оны 2 дугаар сарын 08-ны А/80 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны дугаар сарын 15-ны өдрийн дугаар захирамжийн хавсралт

2023 онд төсөвт өртөг нэмэгдсэн төсөл, арга хэмжээний жагсаалт

№	Хуулийн дугаар	Төслийн нэр, хүчин чадал	Эхлэх он	Дуусах он	Анх батлагдсан төсөвт өртөг	2023 онд төсөвт өртөг нэмэгдсэн дүн	Үнийн өсөлтийн дүн	Нийт төсөвт өртөг	Батлагдсан төсвийн дагуу байгуулсан гэрээний дүн	Өмнө онуудад олгосон санхүүжилт	2023 онд гэрээ байгуулах болон худалдан авах арга хэмжээ зохион байгуулах дүн	2023 онд санхүүжээр батлагдсан дүн	2024 онд санхүүжих /Илдэгдэл/	2023 онд гэрээ байгуулах болон худалдан авах ажиллагааг зохион байгуулах эсэх
1	IX.1.147	Сумын төвийн гадна цэвэр усны шугам сүлжээ (Хэнтий, Жаргалтхаан сум)	2020	2023	242.0	470.9	-	712.9	240.7	211.5	470.9	470.9	-	Худалдан авах ажиллагааг зохион байгуулах
2	IX.1.170	Цэвэр усны гадна шугам сүлжээ (Хэнтий, Өмнөдэлгэр сум)	2021	2023	1,482.0	567.9	159.2	2,209.1	1,450.8	1,450.8	567.9	567.9	-	ТБОНӨБАУХА тухай хуулийн 40.6-р заалтын дагуу гэрээ байгуулах
3	IX.1.177	Гэр хорооллын инженерийн шугам сүлжээ (Хэнтий, Хэрлэн сум)	2022	2024	29,950.0	-	-	51,279.62	29,806.7	5,400.0	-	16,316.4	8,090.3	Гэрээний дагуу үргэлжилж буй ажил
4	IX.1.131	Сумдын усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, инженерийн шугам сүлжээ (Хэнтий, Баян-Адрага, Баян-Овоо, Баянхутаг, Дадал, Дэлгэрхаан, Мөрөн, Норовлин, Цэнхэрмандал сум, Батноров сум, Бэрх тосгон)	2022	2023	11,063.4	7,728.51	-	18,980.5	10,561.68	4,555.78	14,235.8	14,235.8	-	ТБОНӨБАУХА тухай хуулийн 40.6-р заалтын дагуу гэрээ байгуулах
		Дүн			42,737.4	30,285.5	159.2	73,182.1	42,059.8	11,618.1	36,952.0	33,938.7	27,419.9	